

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2023/11

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2023.XI	2022.XI	2023.X	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2023 оны 3-р улирал	их наяд ₮, оны үнээр	46.5	35.2	46.5	-	-	-	6.9% ▲
Инфляц	хувь	8.6	14.5	9.0	0.8% ▲	-	7.5% ▲	-5.9 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин, 2023УЗ	хувь	5.2% 2023 оны УЗ	5.4% 2022 оны УЗ	5.2% 2023 оны УЗ	-	-0.6% ▼ нэгж хувиар	-	-0.2% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1947	-1147	2062	-114 ▼	-	-	3094 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3440.64	3406.43	3452.50	-11.86 ▼	-	-	34.21 ▲
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	5435.6	3273	4914.4	521 ▲	-	-	2162 ▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	60	27.2	52	158% ▲	-	-	2.2 дахин ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	1393	1291	1272	0.2% ▲	-	-	8% ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	13%	12%	13%	0%	-	0%	1% ▲
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	4.2	2.9	3.9	8% ▲	-	-	46% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	8.11%	10.44%	8.29%	-0.17 нэгж хувиар ▼	-	-	-2.33 нэгж хувиар ▼

ОНЦЛОХ СТАТИСТИК:

Нүүрсний экспортын хэмжээ 60 сая тоннд хүрэв	Манай улс 2023 оны төсөвт 50 сая тонн нүүрс экспортлохоор тооцоолжээ. 11-р сарын байдлаар нүүрсний экспортын хэмжээ 60 сая тоннд хүрч, төлөвлөсөн хэмжээнээс даруй 10 сая тонноор нэмэгдсэн байна.
Жуулчид нэг тэрбум орчим ам.долларын орлого оруулав.	2023 оны 11-р сарын 3-ны байдлаар 600,000 гаруй жуулчин Монгол Улсад ирж, дунджаар нэг тэрбум орчим ам.долларын орлогыг дотоодын эдийн засагт оруулсан хэмээн БОАЖЯ-ны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газраас мэдээллээ.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
2012 оны дөрөвдүгээр сарын 11-нээс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд “Эрдэнэс Тавантолгой”-н 1072 хувьцааг эзэмшүүлнэ	2023/12/20	2012 оны дөрөвдүгээр сарын 11-нээс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд тус компанийн 1072 хувьцааг үнэ төлбөргүй эзэмшүүлэх зорилгоор тогтоолын төслийг боловсруулжээ. Цаашид 2024 оны нэгдүгээр сарын 01-нээс шинээр төрсөн Монгол Улсын иргэн бүрд “Эрдэнэс-Тавантолгой”-н хувьцааг шууд эзэмшүүлэхээр тогтоолын төсөлд тусгажээ.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График

Нөлөөлөл


Инфляц



Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 11 дүгээр сард 14.5 хувь гарсан бол 2023 оны 11 дүгээр сард 8.6 хувь болж, өсөлтийн хурдац өмнөх оны мөн үеэс 5.9 нэгж хувиар буурсан байна.


Улсын инфляцад бензин, түлшнээс бусад импортын барааны үнэ 3.0 нэгж хувиар (35.0%), мах, хатуу түлшнээс бусад дотоодын барааны үнэ 4.2 нэгж хувиар (48.9%) тус тус нөлөөлсөн байна

Валютын ханш




Америк долларын ханш 2023 оны 11 дугаар сард 3440.64 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 34 төгрөгөөр чангарч, өмнөх сараас 11.8 төгрөгөөр суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 8%, өнгөрсөн жилийн мөн үеэс 46%-иар өсөж, 4.2 тэрбум ам.долларт хүрэв.

Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2023 оны эхний 11 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 21.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.9 (37.6%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 20.7 их наяд төгрөгт хүрч, 6.3 (43.6%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Урсгал шилжүүлэгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал 2023 оны эхний 11 сард 1.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.5 (4.1 дахин) их наяд төгрөгөөр өсөхөд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг “Нийгмийн халамжийн тухай” хуулийн дагуу халамжийн зардалд тусгах болсоноос шалтгаалжээ.

Гадаад худалдаа



Монгол Улс 2023 оны эхний 11 сард нийт 162 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 22.2 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс экспорт 13.8 тэрбум ам.доллар, импорт 8.4 тэрбум ам.доллар болж, тэнцэл 5.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.2 (16.6%) тэрбум ам.доллароор, экспорт 2.7 (23.9%) тэрбум ам.доллароор, импорт 503.2 (6.4%) сая ам.доллароор, тэнцэл 2.2 (65.9%) тэрбум ам.доллароор тус тус өсжээ.

Дэлхийн эдийн засагт

- Дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2022 онд 3.4 хувь байсан бол өсөлт 2023 онд 2.8 хувь болж буурч, 2024 онд 3.0 хувьд хүрэх төлөвтэй байна.

Эх сурвалж: Олон улсын валютын сан

- Инфляц бүс нутгийн хэмжээнд 2023 онд 4.2%, 2024 онд 3.3% буурах төлөвтэй байгаа N⁰

Эх сурвалж: Азийн хөгжлийн банк, <https://ikon.mn/n/2tv5>

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 11-р сар 2023 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 11-р сар 2023 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn